



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/768

Номгон

「 Төрийн байгууллагуудыг шинэ жил
тэмдэглэхийг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсын Засгийн газрын 57 дугаар хуралдаанаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу коронавируст халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудыг "Шинэ жилийн баяр" тэмдэглэхийг хориглосугай.

2. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримталж, вакцины 3 дугаар тунд хамрагдахыг нийт төрийн албан хаагчдад уриалсугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, шинэ жилийн баярыг тэмдэглэхгүй байх талаар арга хэмжээ авч ажиллахыг Сумдын Засаг дарга, төрийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ж.Алтангэрэл), Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (Б.Оюутболд) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210807